

ГАДААД ХЭЛ СУРАХ ХЭВ МАЯГ, СУРАХ АРГА БАРИЛЫН ХОЛБОО ХАМААРЛЫГ СУДАЛСАН НЬ

Д.Лхамхүү, доктор, НХУС

Хураангуй: Багшийн сургах арга зүй нь суралцагчийн сурах онцлогт тохирч байгаа нөхцөлд суралцагч амжилт гаргах боломжтой бөгөөд эсрэг тохиолдолд сурах хандлага нь суларч, хичээлдээ сонирхолгүй болох, цаашилбал сурлагаар хоцроход хүргэж болох юм. Нөгөө талаас, суралцагч өөрийн сурах хэв маягийг танин мэдсэнээр түүндээ тохирсон оновчтой арга барилыг сонгон, сурах үйл явцыг өөрөө төлөвлөж, жолоодож, хянаж сурах нь гадаад хэлийг амжилттай суралцахын үндэс болно. Тодруулбал, суралцагчдад зөвхөн мэдлэг эзэмшүүлэх нь хангалтгүй бөгөөд харин чадваржуулах, эзэмшсэн мэдлэг, чадвараа өөрийн амьдрал, үйл ажиллагаанд хэрэглээ болгон бүтээлчээр ашиглах, цаашид амьдралын турш тасралтгүй суралцаж чаддаг болох нь чухал болоод байна.

Түлхүүр үг: гадаад хэл сурах хэв маяг, сурах арга барил, холбоо хамаарал, экстраверт, интроверт, метакогнитив, когнитив барил

Оршил

Суралцагч гадаад хэлийг амжилттай сурах нь зөвхөн хувь хүний авьяас, хичээл зүтгэлээр тодорхойлогдохгүй нас, сэдэлтэмүүлэл, хувь хүний онцлог, хэв маяг, сургалтын орчин, багшийн арга зүй зэрэг олон хүчин зүйлийн нэгдэл, нөлөөллөөс шалтгаална. Тиймээс багшийн үйл ажиллагаа нь суралцагчдын зорилго, хэрэгцээ сонирхол, сурах хэв маяг, онцлогийг таньж мэдсэний үндсэн дээр тэдэнд өөрсдийгөө цаашид хөгжүүлэх арга барил олж авахад нь туслан дэмжихэд чиглэх ёстой болж байна. Сурах арга барилтай байна гэдэг нь насан туршид сурах үйлийг өөрийн сурах хэв маягт тохирсон хэлбэрээр бие даан амжилттай зохион байгуулан өөрийн хүссэн үр дүнд хүрэх, сурлагын хоцрогдлоо арилгах, аливаа тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замуудыг эрэлхийлэх, олох арга барил эзэмшихийг хэлнэ. Хэрвээ суралцагч өөрийн зорилгодоо хүрэх арга замаа тодорхойлох чадвартай бол түүний сурах хүсэл сонирхол болон өөртөө итгэх итгэл нэмэгдэнэ гэсэн үг юм (Rampillon 1996, Klippert 1997). Үүнийг дүгнэн Гротъян (Grotjahn) суралцагчийн сурлагын амжилтын 40 хүртэлх хувийг сурах болон ажиллах арга барилын чанартай холбон тайлбарлаж болох юм гэж хэлсэн байна. Суралцагч өөрийн сурах хэв маягийг танин мэдсэнээр түүнд тохирсон оновчтой барилыг сонгон сурах үйл явцыг өөрөө төлөвлөн, жолоодож, хянаж сурах нь гадаад хэлийг амжилттай суралцахын үндэс болно. Учир нь хувь хүний биологийн онцлог, дадаж сурсан зуршил хэв маяг нь ямар барилыг сонгон хэрэглэхэд нөлөөлдөг гэж үзсэн байна (Эрманн/Оксфорд 1989). Оксфорд-ын явуулсан олон эмпирик судалгаа суралцагчийн ашиглаж буй барилууд

тухайн хувь хүний сурах хэв маягийн хооронд холбоо хамаарал байна гэдгийг баталжээ (Эрманн/Оксфорд 1989). Сурах арга барил болон сурах хэв маяг хоорондын холбоо хамаарлыг П.Кирби (P.Kirby, 1979) дараах байдлаар тайлбарласан байна. Сурах барил нь асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн, ухамсартайгаар сонгон хэрэглэж буй техник, тактикууд юм. Харин сурах хэв маяг бол өгөгдсөн даалгавар, мөн нөхцөл байдлаас шалтгаалахгүйгээр суралцагч өөрийн онцлогт тохирсон барилыг хэрэглэхийг хэлнэ гэсэн байна. Сурах хэв маяг нь хувь хүний онцлог шинж, дадал зуршлыг агуулдагаараа сурах барил болон техникээс ялгаатай гэжээ. Германы эрдэмтэн К.Агуадо (K.Aguado, 2010) сурах арга барилд сурах хэв маягийн үзүүлж буй нөлөөллийг тайлбарлахдаа сэтгэл судлалын асуудал болох хувь хүний онцлог хэв шинжийг нэмж оруулсан байдаг. Байгалиас заяасан эсвэл бүр нялхаас тогтсон зан чанартай уялдсан, аливаа зүйлийг хүлээж авах, мэдээллийг боловсруулах тогтвортой шинж чанарыг өөртөө агуулсан хувь хүний хэв шинж нь сурах хэв маягт өөрийн нөлөөгөө үзүүлж байхад сурах хэв маяг нь сурах арга барилд нөлөөлж байдаг гэжээ. Тэгэхээр сурах хэв маяг нь хувь хүний онцлог хэв шинж болон сурах арга барил хоёрын хооронд уялдуулан зохицуулах үүргийг гүйцэтгэнэ. Сурах барил нь ухамсартай, ухамсарлаж болохуйц, сурах боломжтой үйлдлүүд юм. Тэгэхээр суралцагч сурах хэв маягаа ухамсарлаж, танин мэдэж чадвал өөрийн онцлогт тохирсон сурах арга барилыг эзэмшин, сурах үйлдээ ашиглан амжилттай суралцах боломжтой. Суралцагчийн хувьд өвөрмөц онцлог нь болох оюуны шинж төлөв, сурах үйл, сэтгэхүйн хандлагуудыг

харгалзан сурах хэв маягийн үүргийн тухай дараах ойлголтыг тодорхойлж болох юм. Өөрөөр хэлбэл, сурах хэв маяг нь мэдээллийн урсгал дотроос аль чухал гэж үзсэн, тодорхой хэсгийг сонгох, түүнийг цаашид боловсруулах үйл ажиллагаа уруу чиглүүлж өгөх (*selektiv*), тухайн шинээр олж авсан мэдээллийг өмнө нь хуримтлуулсан мэдээлэлтэй уялдуулж зохион байгуулах (*organisieren*), үйл ажиллагааны цаашдын хандлагыг тодорхойлох (*handlungssteuernd*) үүрэгтэй байдаг. Мөн дараагийн алхам болох сурах хэв маягийн удирдан чиглүүлэх (*verhaltenssteuernd*) үүрэг нь сурах барилыг тодорхойлж болох талтай. Тодруулбал, сурах хэв маяг нь ямар барил болон техникийг хэрэглэж, мэдээллийг өөрийн болгох үйл ажиллагааг удирдан чиглүүлнэ гэсэн үг юм.¹

Сурах арга барил болон сурах хэв маягийн аль нэг аспект хоорондын холбоо хамаарлыг судалсан судалгаа багагүй хийгдсэн байдаг. Тухайлбал, сурах арга барил болон хүртэхүйн хэв маягийн холбоо хамаарлыг судалсан судалгааны үр дүнг нэгтгэн харвал, хэдий суралцагчийн хэв маяг холимог шинжтэй байх нь элбэг ч мэдээллийг хүлээн авах аль нэг хүртэхүйн чадвар түлхүү хөгжсөн байдаг. Мөн түүнээс гадна сурах хэв маягийг бараг өөрчлөгддөггүй, тогтвортой гэж үздэг ч Р.Оксфорд, Андерсон (Oxford/Anderson, 1995) нар мэдээлэл хүлээн авах хүртэхүйн хэв маягийн аль нь давамгайл хөгжсөн байх нь төрөлхийн биш, харин суралцагчийн нас, хэл соёлын онцлогоос хамаарахын зэрэгцээ сургалтын үйл явцад сонсож ойлгох дасгалын хажуугаар бичгийн даалгавар түлхүү өгч, гадаад хэлний хичээлээр унших чадварыг чухалчлан үздэг нь харааны ойг сайжруулахад нөлөөлөх гадны хүчин зүйл болох боломжтойгоос үзэхэд сургалтын арга зүйн нөлөөллийн талаар дурдах нь зүйтэй юм. Тухайлбал, бага насны суралцагчид ихэнхдээ хөдөлгөөний буюу тактил хэв маягтай байх нь элбэг. Гадаад хэл суралцагч япончууд ихэнхдээ харааны ой сайтай байхад араб болон хятадын гадаад хэл суралцагчид сонсголын ой сайн байх нь судалгааны үр дүнд ажиглагдсан байна. (Oxford/Anderson 1995).

Сурах арга барилыг олон хүчин зүйлийн холбоо хамааралтай нь судалсан эрдэмтэн бол Р.Оксфорд бөгөөд тэрээр сурах хэв маяг болон сурах арга барил хоорондын холбоо харилцааг олон удаагийн хамтарсан судалгаагаар батлан, ямар сурах арга барилыг сонгон хэрэглэвэл үр

дүнтэй вэ гэдгийг тухайн суралцагчийн сурах хэв маяг тодорхойлно гэжээ. (Ehrman/Oxford 1989) Oxford/Ehrmann 1995 нар Америкийн гадаад хэлний эрчимтэй сургалтын дамжаанд суралцаж буй насанд хүрэгчдийн сурах арга барил болон сурах хэв маягийг тогтоох зорилгоор 520 суралцагчаас судалгаа аван дараах дүгнэлтийг хийсэн байна. Үүнд:

1. Когнитив арга барилыг түлхүү ашиглаж буй суралцагчид тэсвэр хатуужилтай, сэдэл тэмүүлэлтэй, юмаа системтэй төлөвлөдөг, амжилттай суралцдаг, өмнө нь өөр хэл судалж байсан, өөдрөг үзэлтэй, эрч хүчтэй.
2. Нөхөх барилыг ашиглаж буй суралцагчид хэлний авьяастай, хичээлээс гадуур сурч буй хэлээ хэрэглэнд оруулах сонирхолтой, алдаа хийхээс айдаггүй.
3. Метакогнитив барилыг ашиглаж буй суралцагчид тэсвэр хатуужилтай, өндөр боловсролтой, эмх цэгц, төлөвлөгөөтэй ажилладаг, хүнтэй амархан дотносдоггүй, сэтгэлгээ сайтай, харийн хэл соёлыг сонирхдог, ухамсартай.
4. Нийгэмшихүйн барилыг түлхүү ашиглаж буй суралцагчид бусад барилыг мөн адил ашигладаг, өөрийгөө илэрхийлэх чадвар өндөр, тэсвэр тэвчээртэй, аливаа зүйлд бодитоор ханддаг гэжээ.

Хувь хүний онцлогийн зэрэгцээ улс орны соёлын онцлог сурах хэв маяг болон сурах арга барилд чухал үүрэг гүйцэтгэдэг. Зарим улс орны хувьд олон нийтийн газар, ялангуяа хичээл дээр ихэвчлэн дуугүй, бие барьсан байдалтай байдаг нь тухайн суралцагч олны дунд тэр тусмаа багшийн эсвэл өрөөлийн өмнө эвгүй байдалд орохоос эмээдэгтэй холбоотой. Эдгээр суралцагч нь ихэвчлэн дотогшоо чиглэсэн болон орчноос хараат бус хэв маягтай байдаг (Huneke, H.-W. / Steinig (2005). Oxford, Anderson (1995), Reid (1995) нарын хийсэн судалгаагаар испани хэлтэн /өмнөд америкийн/ суралцагчид ихэнхдээ мэдээллийг ерөнхийлөн хүлээн авах хэв маягтай байхад англи, америк суралцагчид мэдээллийг нарийвчлан, нухацтай ойлгохыг хичээдэг байна. Япон суралцагч алдаа хийхээс зайлсхийдэг, аливаад хянуур болгоомжтой хандах хэв маягтай байхад испани хэлтэн /өмнөд америкийн/ суралцагч алдаа хийхээс эмээдэггүй нь судалгаагаар ажиглагджээ. Үүний зэрэгцээ Oxford (1995) гадаад хэл суралцаж буй эмэгтэй суралцагч аливаад хянуур, болгоомжтой ханддаг байхад, эрэгтэй суралцагч дасгал даалгаврыг удаан бодож эргэцүүлэлгүй шууд хийж эхэлдэг

1 Grotjahn, R. (1998): *Lernstile und Lernstrategien: Definition, Identifikation, unterrichtliche Relevanz. Der fremdsprachliche Unterricht Französisch* 34, x. 11-16.

гэжээ. Мөн испани хэлтэн суралцагчийг бодвол араб хэлтэн суралцагч нь тэсвэр хатуужил муутай гэж дүгнэгджээ.

Хэдийгээр эрдэмтэд сурах арга барил нь нас, хувь хүний онцлог, сэдэл тэмүүлэл, хэл сурах чадвар зэрэг олон хүчин зүйлтэй холбоо хамааралтай гэж таамаглан, нотолж байгаа ч эдгээрийн хоорондын холбоо хамаарлыг системтэй судалсан судалгаа төдийлөн хангалттай биш, суралцагчийн мэдээллийг хүлээн авч, танин мэдэх үйл явцыг түлхүү судлан, харин нийгмийн болон улс орны соёлын асуудлуудыг орхигдуулсан байгаа нь ажиглагдаж байна. Тиймээс сурах арга барил, сурах хэв маягийн талаарх судалгааг шууд нэгтгэж дүгнэн, тодорхой дүр зургийг олж харахад бэрхшээлтэй байдаг. Эрдэмтэн К.Агуадо (Aguado, 2007) сурах арга барил, сурах хэв маягийн талаар хийгдсэн зарим судалгаа бодит нөхцөл байдлаас тасархай, зөвхөн сурах үйл явцыг судалсан хэмээн шүүмжилж, тухайлсан тодорхой сурах үйл явцад ямар хэв маягтай суралцагч, ямар сурах арга барилыг ашиглаж байгааг ажиглан судалбал ач холбогдолтой гэж дүгнэжээ.

Гадаад хэл сурах хэв маяг, сурах арга барилын холбоо хамаарлыг тогтоох судалгаа

Энэхүү судалгаагаар гадаад хэл суралцагчийн сурах хэв маяг ба тэдгээрийн эзэмшсэн сурах арга барилын хоорондын хамаарал, энэ нь гадаад хэлний амжилтад хэрхэн нөлөөлж буйг тогтоох зорилгыг дэвшүүлсэн болно. Тус судалгаанд

МУБИС-ийн “герман хэлний багш” мэргэжлээр суралцаж буй нийт 68 оюутан, үүнээс 60 нь эмэгтэй, 8 нь эрэгтэй оюутан хамрагдсан.

Гадаад хэл суралцагчийн сурах хэв маягийг тодорхойлох судалгаандаа Ребека Оксфордын боловсруулсан SAS /Style Analysis Survey/, сурах арга барилыг 50 асуултаас бүрдэх “Strategy Inventory for Language Learning (SILL)” судалгааны стандарт асуулгыг суурь болгон ашигласан болно.

Суралцагч өөрийн сурах хэв маягийг танин мэдсэнээр түүнд тохирсон оновчтой барилуудыг сонгон сурах үйл явцыг өөрөө төлөвлөн, жолоодож, хянаж сурах нь гадаад хэлийг амжилттай суралцахын үндэс болно. Иймээс а) хувь хүний биологийн онцлог, дадаж сурсан зуршил хэв маяг хоорондоо хэрхэн холбоотой, б) суралцагчийн ашиглаж буй барилууд хоорондоо хэрхэн холбоотой, в) суралцагчийн ашиглаж буй барил хэв маягтай хэрхэн уялдаж байгаа, г) амжилттай суралцахад ямар арга барил, хэв маяг нь хоорондоо харилцан уялдан нөлөөлж байгааг корреляцийн (Spearman's rho) шинжилгээ хийж тодорхойлсон. Энэхүү шинжилгээний үр дүнг дээрх бүлгүүдээр задалж шинжиллээ.

а) хувь хүний биологийн онцлог, дадаж сурсан зуршил хэв маяг хоорондын уялдаа холбоо

Суралцагчийн хэв маягуудын хоорондох хамаарлыг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1

Сурах хэв маяг хоорондын холбоо хамаарал

Spearman's rho Correlations	харааны	сонсголын	үйл хөдлөлийн	экстрроверт	интроверт	зөгнөн баримжаалах	конкрет	глобал	нарийвчлан задлах	дедуктив	индуктив
харааны	1	,262(*)			,425(**)	,322(**)	,356(**)		,554 (**)		
сонсголын	,262(*)	1		,381(**)	,299(*)	,468(**)			,368 (**)		
үйл хөдлөлийн			1				,285(*)				
экстрроверт		,381(**)		1		,303(*)		,298(*)			
интроверт	,425(**)	,299(*)			1	,242(*)	,451(**)	,262(*)	,434 (**)		
зөгнөн баримжаалах	,322(**)	,468(**)		,303(*)	,242(*)	1			,341(**)	,239(*)	
конкрет	,356(**)		,285(*)		,451(**)		1		,256(*)	,258(*)	
глобал				,298(*)	,262(*)			1			
нарийвчлан задлах	,554(**)	,368(**)			,434(**)	,341(**)	,256(*)		1	,350(**)	,264(*)
дедуктив						,239(*)	,258(*)			1	
индуктив									,264(*)		1
* Correlation is significant at the 0.05 level (2-tailed).											
** Correlation is significant at the 0.01 level (2-tailed).											

Хүснэгтэд (**) гэсэн тэмдэглэгээ нь статистикийн 1%, (*) статистийн 5%-ийн ач холбогдлын түвшинд хэв маягуудын хамаарлыг үзүүлдэг.

Хүртэхүйн хэв маягууд а) Харааны ой тогтоолт нь сонсголын, интроверт, зөгнөн баримжаалах, хянуур, нарийвчлан задлах, б) сонсголын ой тогтоолт нь харааны, экстраверт, интроверт, зөгнөн баримжаалах, нарийвчлан задлах, в) хөдөлгөөний хэв маяг нь хянуур зэрэг хэв маягуудтай хамааралтай байна. Харааны болон сонсголын хэв маягууд нь хоорондоо холбоотой байгаагаас үзэхэд суралцагчдын ихэнх нь харааны болон сонсголын хүртэхүйгээр мэдээллийг хүлээж авдаг бөгөөд энэ нь сонсох, унших, бичих даалгавар давамгайлсан манай уламжлалт заах аргагүйтэй холбоотой байж болох талтай.

Хувь хүний онцлогт суурилсан хэв маягууд а) Шинжилгээгээр экстраверт хэв маяг нь сонсголын, зөгнөн баримжаалах болон ерөнхийлөн тоймлох, б) интроверт хэв маяг нь харааны, сонсголын, зөгнөн баримжаалах, хянуур, ерөнхийлөн тоймлох, нарийвчлан задлах зэрэг хэв маягуудтай уялдаа холбоотой байна. Дээрх уялдаа хамаарлаас харахад нээлттэй шинж чанарыг илтгэх экстраверт суралцагч нь бүтээлчээр ургуулан бодож чаддаг, аливаа зүйлд өөрийн мэдрэмжээрээ ханддаг, мэдээллийн гол утга санааг ойлгохыг хичээдэг байхад интроверт суралцагч нь холимог шинжтэй байгаа ч харааны, хянуур, нарийвчлан задлах хэв маягуудтай өндөр хамааралтай байгаа нь үзүүлэлтээс харагдаж байна. Иймээс интроверт суралцагч нь нарийн зааварчилгаа, эмх цэгц, логик дэс дарааллыг хүсдэг зэрэг шинжүүдийг нэрлэж болно.

Когнитив хэв маягууд а) зөгнөн баримжаалах хэв маяг нь харааны, сонсголын, экстраверт, интроверт, нарийвчлан задлах, дедуктив, б) хянуур хэв маяг нь харааны, хөдөлгөөний, интроверт, нарийвчлан задлах, дедуктив, в) ерөнхийлөн тоймлох хэв маяг нь экстраверт болон интроверт, г) нарийвчлан задлах хэв

маяг нь харааны, сонсголын, интроверт, зөгнөн баримжаалах, хянуур, дедуктив хэв маяг нь зөгнөн баримжаалах, хянуур, нарийвчлан задлах, д) дедуктив хэв маяг нь нарийвчлан задлах зэрэг хэв маягуудтай холбоо хамааралтай байгааг үзүүлэлтүүдээс харж болно. Эдгээрээс үзэхэд хянуур болон нарийвчлан задлах хэв маягууд нь зөвхөн интроверт хэв маягтай холбоотой байхад зөгнөн баримжаалах болон ерөнхийлөн тоймлох хэв маягууд экстраверт болон интроверт хувь хүний онцлогт суурилсан хэв маягуудтай ижил хамааралтай байна. Асуудлын нарийн жижиг зүйлд ч гэсэн анхаарлаа хандуулдаг нарийвчлан задлах хэв маягтай суралцагч нь хэл зүйн дүрмийг индуктив аргаар буюу дасгал даалгавраас задлан шинжилж гаргах хүсэлтэй байдгийг нь хүснэгтээс үзэж болно.

Судалгаанд хамрагдсан гадаад хэл суралцагчдад хүртэхүйн хэв маягуудаас харааны ой тогтоолт нь давамгайлсан үр дүн гарсан бөгөөд дээрх хамаарлын хүснэгтээс үзэхэд энэ хэв маяг нь сонсголтой холбоотой байна. Хувь хүний онцлогт суурилсан хэв маягуудаас суралцагчид гол төлөв экстраверт хэв маягтай, харин мэдээллийг хүлээн авах хэв маягуудаас зөгнөн баримжаалах, ерөнхийлөн тоймлох болон дедуктив хэв маяг давамгайлсан байсан бөгөөд дээрх хүснэгтээс харахад эдгээр хэв маягууд нь бие биетэйгээ холбоотой байхын зэрэгцээ нарийвчлан задлах, хянуур зэрэг хэв маягтай хамааралтай болох нь тодорхой байна. Өөрөөр хэлбэл багшийн нарийн зааварчилгаанд дуртай, хэлзүйн дүрэмд илүү анхаарал хандуулдаг байх талтай.

б) суралцагчийн ашиглаж буй барилуудын хоорондын холбоо хамаарал.

Суралцагчийн ашиглаж буй барилуудын хоорондын хамаарлыг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 2. Сурах барил хоорондын холбоо хамаарал

Spearman's rho	Ой тогтоолт	Когнитив	Нөхөх	Метакогнитив	Аффектив	Нийгэмшихүйн
Ой тогтоолт	1	,549(**)	,356(**)	,546(**)	,284(*)	,328(**)
Когнитив	,549(**)	1	,498(**)	,539(**)		,350(**)
Нөхөх	,356(**)	,498(**)	1			,402(**)
Метакогнитив	,546(**)	,539(**)		1	,518(**)	,418(**)
Аффектив	,284(*)			,518(**)	1	,285(*)
Нийгэмшихүйн	,328(**)	,350(**)	,402(**)	,418(**)	,285(*)	1

* Correlation is significant at the 0.05 level (2-tailed).

** Correlation is significant at the 0.01 level (2-tailed).

Дээрх хүснэгтээс а) ой тогтоолтын болон нийгэмшихүйн барилууд нь когнитив, нөхөх, метакогнитив, нийгэмшихүйн, б) когнитив нь аффектив буюу сэтгэл хөдлөлөө жолоодох барилаас бусад, в) нөхөх барил нь ой тогтоолт, когнитив, нийгэмшихүйн, г) метакогнитив барил нь нөхөх барилаас бусад, д) аффектив барил нь ой тогтоолт, метакогнитив болон нийгэмшихүйн зэрэг барилтай хамааралтай байгаа нь харагдаж байна.

Метакогнитив, когнитив болон ой тогтоолтын барилууд харьцангуй өндөр хамааралтай байхад аффектив, нийгэмшихүйн барилуудын холбоо хамаарал бага байгааг хүснэгтээс харж болно.

в) суралцагчийн ашиглаж буй барил ба сурах хэв маягийн хоорондын холбоо хамаарал

Хамаарлын шинжилгээний үр дүнг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 3

Сурах хэв маяг, сурах арга барилын хоорондын холбоо хамаарал

Spearman's rho Correlations	Ой тогтоолт	Когнитив	Нөхөх	Метакогнитив	Аффектив	Нийгэмшихүйн
Харааны	,398(**)					
Сонсголын	,281(*)			,260(*)		
Хөдөлгөөний						
Экстрове́рт						
Интроверт						
Зөгнөн баримжаалах	,314(**)	,364(**)	,514(**)	,433(**)		,267(*)
Хянуур					,245(*)	
Ерөнхийлөн тоймлох		,283(*)	,242(*)			
Нарийвчлан задлах	,357(**)	,271(*)	,312(**)	,262(*)		
Дедуктив				,243(*)		,328(**)
Индуктив						

Дээрх хүснэгтээс сурах хэв маяг, ашиглаж буй барил хоорондын холбоо хамаарлыг тодорхойлбол:


а) Харааны хэв маяг нь ой тогтоолтын барилтай, б) сонсголын хэв маяг нь сонсголын болон метакогнитив, в) зөгнөн баримжаалах хэв маяг аффектив буюу сэтгэл хөдлөлөө жолоодох барилаас бусад, г) хянуур хэв маяг нь аффектив, д) ерөнхийлөн тоймлох хэв маяг когнитив болон нөхөх, е) нарийвчлан задлах хэв маяг аффектив болон нийгэмшихүйн барилаас бусад ё) дедуктив

барил метакогнитив болон нийгэмшихүйн зэрэг барилтай тус тус холбоо хамааралтай байна. Харин хувь хүний онцлогт суурилсан экстрове́рт ба интроверт хэв маягуудын хувьд сурах барилтай холбоо хамаарал илэрсэнгүй. Үүнээс дүгнэхэд ямар сурах арга барил ашиглах нь хүртэхүйн болон когнитив хэв маягуудаас шалтгаалах боломжтой байх талтай.

Энэхүү хүснэгтэд үзүүлсэн хамаарлуудыг дүгнэн үзэхэд сурах барилууд нь дараах хэв маягуудтай холбоо хамааралтай байна (Бүдүүвч 10).

Бүдүүвч 1

Сурах хэв маяг, арга барилын холбоо хамаарал



г) гадаад хэл амжилттай сайн сурахад сурах арга барил, хэв маягийн нөлөөлөл

Сайн суралцагч

Сайн буюу амжилттай суралцагчид тухайн хэлний стандартын хэмжээний мэдлэг, дадал, чадварыг бүрэн эзэмшиж чадсан суралцагчийг тооцдог. Суралцагчийн хэлний түвшинг илрүүлэх үнэлгээний янз бүрийн арга хэлбэрээс энэхүү судалгаанд суралцагчийн амжилтыг тогтоохдоо Европын хэлний нэгдсэн стандартын өөрийн үнэлгээний анкет, түвшин тогтоох тест болон багшийн үнэлгээг харгалзан үзсэн болно. Өмнөх шинжилгээгээр хэлний түвшин сайн буюу 100-80 оноотой үнэлэгдсэн суралцагчид сурах хэв маягийн хувьд зөгнөн баримжаалах болон хөдөлгөөний, харин сул суралцагчид хянуур хэв маягтай болохыг тодорхойлсон билээ. Мөн түүнчлэн сайн суралцагч сурах арга барилын хувьд когнитив барилыг ($P=0.021<0.05$) сул суралцагчидтай харьцуулбал илүү ашигладаг болохыг өмнөх шинжилгээгээр гаргасан юм.

Сурах хэв маяг, сурах арга барилын холбоо хамаарлыг тогтоох шинжилгээний дүгнэлт

Энэ шинжилгээгээр суралцагчийн хэв маяг нь арга барилтай хэрхэн холбогдож байгааг тодорхойллоо. Шинжилгээний үр дүн өмнөх бүлгүүдэд хийсэн үр дүнгүүдтэй уялдаж байгааг тэмдэглэж байна. Үүнд:

1. Харааны болон сонсголын хэв маягууд нь хоорондоо холбоотой байгаагаас үзэхэд суралцагчдын ихэнх нь харааны болон сонсголын хүртэхүйгээр мэдээллийг хүлээж авдаг бөгөөд үүнд ярих, сонсох, унших, бичих даалгавар давамгайлсан манай уламжлалт заах аргазүй нөлөө үзүүлж болох талтай.
2. Хувь хүний онцлогт суурилсан хувь хүний нээлттэй шинж чанарыг илтгэх экстраверт суралцагч нь бүтээлчээр ургуулан бодож чаддаг, аливаа зүйлд өөрийн мэдрэмжээр ханддаг, мэдээллийн гол утга санааг ойлгохыг хичээдэг байхад интроверт суралцагч нь холимог шинжтэй байгаа ч харааны, хянуур, нарийвчлан задлах хэв маягуудтай өндөр хамааралтай байгаа нь үзүүлэлтээс харагдаж байна. Иймээс интроверт буюу дуугүй суралцагч нь нарийн зааварчилгаа, эмх цэгц, логик дэс дарааллыг хүсдэг зэрэг шинжийг нэрлэж болно.
3. Эдгээрээс үзэхэд хянуур болон нарийвчлан

задлах хэв маяг нь зөвхөн интроверт хэв маягтай холбоотой байхад зөгнөн баримжаалах болон ерөнхийлөн тоймлох хэв маяг, экстраверт болон интроверт хувь хүний онцлогт суурилсан хэв маягуудтай ижил хамааралтай байна. Асуудлын нарийн жижиг зүйлд ч гэсэн анхаарлаа хандуулдаг нарийвчлан задлах хэв маягтай суралцагч нь хэл зүйн дүрмийн индуктив аргаар буюу дасгал даалгавраас задлан шинжилж гаргах хүсэлтэй байдгийг нь хүснэгтээс үзэж болно.

4. Харааны, сонсголын, зөгнөн баримжаалах, ерөнхийлөн тоймлох, нарийвчлан задлах болон дедуктив хэв маяг сурах барилтай уялдаатай байхад хувь хүний онцлогт суурилсан экстраверт ба интроверт хэв маягуудын хувьд сурах барилтай холбоо хамаарал илэрсэнгүй. Үүнээс дүгнэхэд ямар сурах арга барил ашиглах нь хүртэхүйн болон когнитив хэв маягуудаас шалтгаалах боломжтой байх талтай.
5. Сайн суралцагч зөгнөн баримжаалах хэв маягтай буюу бүтээлчээр ургуулан бодож чаддаг, аливаа зүйлийн учир шалтгааныг олон талаас нь эргэцүүлэн бодохыг хичээдэг, шинийг эрэлхийлдэг, алдаа хийхээс айдаггүй байхад сул суралцагч нь хянуур хэв маягтай буюу сахилга баттай, хүмүүстэй хурдан дотно болдоггүй, хэрэв багаар ажиллаж байгаа тохиолдолд аль болох чимээгүйхэн сонсохыг илүүд үздэг, нарийн зааварчилгаанд дуртай байх хандлагатай байна.
6. Зөгнөн баримжаалах хэв маягтай сайн суралцагчид алдаа хийхээс айдаггүй тул сэтгэл хөдлөлөө жолоодох барилуудыг ашигладаггүй харин бусад барилуудыг ихэнхдээ ашигладаг байна. Гэтэл хянуур хэв маягтай сул суралцагчид аффектив барилыг хэрэглэх нь элбэг гэсэн өмнөх шинжилгээний дүгнэлт энэхүү шинжилгээгээр батлагдаж байна. Учир нь тэд алдаа хийхээс айж, ичих асуудалтай үргэлж тулгарч байдаг байна.

Талархал

Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэхэд зөвлөгөө, туслалцаа дэмжлэг үзүүлсэн судалгааны ажлын удирдагч акад. Н. Бэгз, дэд. проф. Ц. Бурмаа нартаа баярлаж талархсанаа илэрхийлж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Aguado, K. (2010)., Paedagogisch-didaktische Lernkategorien: Typen von Lernern und Lerntypen“, *Handbuch Deutsch als Fremdsprache*, x. 751-760.
- Andreou, E., Andreou, G., Vlachos, F. (2008): “Learning Styles and Performance in Second Language Tasks”, *TESOL* 42, x. 665-674.
- Artelt, Gordula (1998):, Lernstrategien und Lernerfolg: ein Methodenvergleich“, *LLF-Berichte* Nr 18, Universitaet Potsdam
- Bimmel, P. (1/1993). „Warum sind die Lernstrategien wichtig?“, *Fremdsprache Deutsch*. Muenchen: Verlag Klett Edition Deutsch,
- Bimmel, P. (2007): *Lernerautonomie und Lernstrategien*. Muenchen: Goethe Institut.
- Бурмаа. Ц (2012) Суралцагчдад англи хэл сурах арга барил эзэмшүүлэх аргазүй. Улаанбаатар
- Chang, Hsuan-Chen (2002): Deutsch als Zweitsprache - Eine empirische Untersuchung der Lernstrategien taiwanesischer Studierender im Hinblick auf autonomes Lernen, Uni Bielefeld
- Ичинхорлоо. Ш (2012). Сурах арга, *Улаанбаатар*
- Чимгээ. Д (2011). *SPPS нийгмийн статистикийн шинжилгээ хийх, үр дүнг тайлбарлах*, Улаанбаатар
- Claudio, N. (1996):, Autonomie und Fremdsprachenlernen“, *Fremdsprache Deutsch*, x. 4-10.
- Conrad, Jan Christian (2005): *Lernstrategien als Voraussetzung eines modernen schuelerorientierten Fremdsprachenunterrichts: Klassifikation, Trainingsprogramme und die Rolle der Lehrbuecher*
- Ehrman, M., Oxford, R. (1990): “Adult Language Learning Styles und Strategies an Intensive Training Setting”, *The Modern Language Journal* 74, x. 311-327.
- Grotjahn, R. (1998): *Lernstile und Lernstrategien: Definition, Identifikation, unterrichtliche Relevanz. Der fremdsprachliche Unterricht Franzoesisch* 34, x. 11-16.
- Grotjahn, R. (2003): *Lernstile/ Lernertypen. Handbuch Fremdsprachenunterricht* 326-331.

Боловсрол судлал. 2014/05/103